



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/11/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: Munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: Munkhtuyats@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Албан шаардлага	12
4.2 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/696
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,000,000,000.00	10,000,000,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,000,000,000.00	10,000,000,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,000,000,000.00	10,000,000,000.00
31210	Төгрөг	10,000,000,000.00	10,000,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	10,000,000,000.00	10,000,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,000,000,000.00	10,000,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,000,000,000.00	10,000,000,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	10,000,000,000.00	10,000,000,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	10,000,000,000.00	10,000,000,000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-	10,000,000,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,000,000,000.00	10,000,000,000.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,000,000,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000,000.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000,000.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,000,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,000,000,000.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,000,000,000.00	0.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	10,000,000,000.00	10,000,000,000.00
11	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	10,000,000,000.00	10,000,000,000.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	10,000,000,000.00	10,000,000,000.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	10,000,000,000.00	10,000,000,000.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,000,000,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000,000.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000,000.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,000,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,000,000,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,000,000,000.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,000,000,000.00	10,000,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад Кино урлагийг дэмжих сангийн журмыг батлуулж, мөрдөх, цаашид төсвөөс олгох сангийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар удирдан, зохион байгуулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хооронд ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор Ц.Мөнхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/2667 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Кино урлагийг дэмжих сан нь кино үйлдвэрлэл болоод монгол хүний оюун санааны хөгжлийг хөгжүүлэн дэмжиж, кино урлагаар дамжуулан дэлхийд түүх, өв соёлоо таниулах, олон улсын түвшинд эн зэрэгцэн өрсөлдөх, үндэсний кино урлагийг хөгжүүлэх шинэ алхмыг бий болгохыг зорьж буй бөгөөд кино урлагийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээн таниулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно:

Үүнд:

- монголын түүх, соёл, ахуй амьдралыг харуулах, эсхүл хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, нийгмийн эрүүл мэнд, эрүүл, зөв амьдрах дадал зуршил хэвшүүлэхэд эергээр нөлөөлөх, эсхүл олон улсын кино наадамд өрсөлдөх зорилготой найруулагчийн хувийн бүтээлч чанар, гоо зүйн үнэлэмж, үзэл бодлын илэрхийллийг харуулсан кино бүтээх;
- монгол киног хадгалах, сэргээн хөрвүүлэх;
- олон улсын кино наадам, үзэсгэлэнд монгол киногоор оролцох, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулах;
- кино урлагийн уран бүтээлч, ажилтныг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

Кино урлагийг дэмжих сангийн эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийг дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олгоно:

Үүнд:

- Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1-д зааснаас бусад кино бүтээх;
- кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Кино урлагийг дэмжих тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дугаар тушаал.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Кино урлагийг дэмжих сан 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 10,000.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 150.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 10,000.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,000,000.0	10,000,000.0	-
Нийт хөрөнгө	10,000,000.0	10,000,000.0	-
Хуримтлагдсан үр дүн	10,000,000.0	10,000,000.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,000,000.0	10,000,000.0	-

Мөнгөн хөрөнгийн дансанд өмнөх оны татан төвлөрүүлээгүй 10,000.0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Кино урлагийг дэмжих сангийн журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу журмын төслийг боловсруулан яамдаас санал авсан боловч дээрх журам батлагдаагүйгээс сангийн мөнгөн хөрөнгийн дансанд байршиж буй эх үүсвэрийг зарцуулах эрх үүсээгүй, улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Кино урлагийг дэмжих санд 2021 оны үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэх зардал болоод эх үүсвэр төлөвлөөгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын Их хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Кино урлагийг дэмжих тухай хуулийг баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна. Тус хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт орж, кино урлагийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Кино урлагийг дэмжих тухай хуулиар, нийтлэг харилцааг нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулахаар заасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдсанаар кино бүтээх, түгээхтэй холбоотой цогц үйл ажиллагааг зохицуулахаар “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон шалгуур хангасан банкныг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам” болоод холбогдох бусад журмын төслүүдийг боловсруулсан боловч батлуулж, мөрдөх ажиллагаа удаашралтай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Кино урлагийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан 2020 оны зарцуулаагүй төсөв 10,000.0 сая төгрөгийг жилийн эцэст төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах, хөрөнгө зарцуулах журмыг эрх бүхий байгууллагаар батлуулж мөрдөх, эрх зүйн орчныг бий болгох талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

Хүснэгт-2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1				1		-
Нийт дүн	1				1		-

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Соёлын яамнаас “Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1986 албан бичгээр журмын төсөлд яамдаас санал авах ажиллагааг зохион байгуулсан байна. Сангийн яамнаас уг журмын төсөлд холбогдох саналыг ирүүлж, дахин санал авах тухай албан бичгийг хүргүүлжээ.

Энэхүү хугацаанд Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Кино урлагийг дэмжих тухай хуулийг баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан бөгөөд Кино урлагийг дэмжих тухай хуульд нийцүүлэн журмын төслийг дахин боловсруулах шаардлага үүссэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Кино урлагийн үндэсний зөвлөлийн эрх зүйн орчин, санхүү төсвийн үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, Кино урлагийг дэмжих сангийн журмын үйл явц, хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн асуудлаар аудитын горим, сорил хэрэгжүүлэх нь ач холбогдолтой байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,000.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн мөнгөн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгийг зарцуулах журмыг эрх бүхий байгууллагаар батлуулж мөрдөх, эрх зүйн орчныг бий болгох талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв, санхүүгийн өмнө хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

1.1 Илрүүлэлт:

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкиг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журмыг Засгийн газар батална” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, сангийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг батлуулаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Холбогдох журмыг батлуулж, мөрдөх, цаашид төсвөөс олгох сангийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар удирдан, зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/														
№	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	КУДС	АХГ-2022/11/Н А-СТА-ЗГТС	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн мөнгөн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох	1						1			
	ДҮН				1						1			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	КУДС	АХГ-2022/11/Н А-СТА-ЗГТС	Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, сангийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг батлуулаагүй.	Холбогдох журмыг батлуулж, мөрдөх хэрэгжилтийг хангах	1								1	
	ДҮН				1								1	
	НИЙТ ДҮН				2						1		1	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 673/А0170072

Улаанбаатар хот

АХГ-2022/11/НА-СТА-3ГТС

Сахилгын хариуцлага тооцуулах
албан шаардлага

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Кино урлагийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн мөнгөн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгийг зарцуулах журмыг эрх бүхий байгууллагаар батлуулж мөрдөх, эрх зүйн орчныг бий болгох талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шөтны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсөв, санхүүгийн өмнө хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ц.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10.20\Bichil_Khere\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-308.Docx

0001081651

[illegible]